



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 4/10

Булган сум

**“Спорт бүжиг” хөтөлбөрийг боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV дүгээр хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх “Спорт бүжиг” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын бодлого
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн)
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)
Л.Ганболд (Биеийн тамир, спортын газрын Спортын
хэлтсийн дарга)
Г.Нарантуяа (Биеийн тамир, спортын газрын Биеийн
тамирын хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

2. “Спорт бүжиг” хөтөлбөрийг хууль журмын дагуу оновчтой боловсруулж, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулж, 2025 оны I улиралд батлуулахыг ажлын хэсгийн дарга (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Булган Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010013